



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ” ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан Соёлын төвийн 2021 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ОРА-2022 /75/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Орхон аймаг 2022 он	Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 7035 9826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 7035 8505 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитор: З.Баттуяа Утас: 99550516 Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



1. АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр).....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3.Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4. Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Залруулсан алдаа .....	14
4.2 Төлбөрийн акт .....	14
4.3 Албан шаардлага .....	14
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	<b>Error! Bookmark not defined.</b>

#### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СХДАА	Санхүүгийн Хяналт Дотоод Аудитын Алба
БСУГ	Боловсрол Соёл Урлагын Газар



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.01.28 № 53  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР  
СУМЫН БАЯНЦАГААН СОЁЛЫН  
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ  
С.МӨНХТУЛГА ТАНАА**

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянцагаан соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянцагаан соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,486,460.00</b>	<b>12,504,360.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	11,486,460.00	12,504,360.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	10,992,560.00	11,492,560.00
35110	Тусгай зориулалттай материал	10,992,560.00	11,492,560.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	493,900.00	1,011,800.00
35420	Аж ахуйн материал	427,000.00	944,900.00
35450	Барилгын засварын материал	66,900.00	66,900.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>24,796,538.82</b>	<b>19,017,884.52</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	24,796,538.82	19,017,884.52
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	24,796,538.82	19,017,884.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,369,806.50	33,369,806.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(26,491,117.50)	(29,473,473.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,278,309.00	18,278,309.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,404,256.18)	(9,266,254.98)
39217	Ном	6,043,797.00	6,109,497.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	-
39301	Програм хангамж	685,000.00	685,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(685,000.00)	(685,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>36,282,998.82</b>	<b>31,522,244.52</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>36,282,998.82</b>	<b>31,522,244.52</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	36,282,998.82	31,522,244.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	13,091,747.00	13,091,747.00
51101	Өмч: - төрийн	13,091,747.00	13,091,747.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	23,191,251.82	18,430,497.52
51210	Өмнөх үеийн үр дүн	23,191,251.82	23,191,251.82
51220	Тайлант үеийн үр дүн	-	(4,760,754.30)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>36,282,998.82</b>	<b>31,522,244.52</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>95,362,900.00</b>	<b>85,385,300.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>95,362,900.00</b>	<b>85,385,300.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	95,362,900.00	85,385,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	95,362,900.00	85,385,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>100,584,990.20</b>	<b>90,146,054.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>100,584,990.20</b>	<b>90,146,054.30</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	88,863,036.71	88,992,020.15
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>65,929,790.00</b>	<b>66,011,711.00</b>
210101	Үндсэн цалин	55,921,354.00	46,255,437.11
210102	Нэмэгдэл	7,417,785.00	16,147,474.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,741,298.00	3,608,799.69
210104	Урамшуулал	849,353.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>7,266,525.00</b>	<b>8,318,357.94</b>
210201	Тэтгэврийн даатгал	5,439,925.19	5,929,633.63
210202	Тэтгэмжийн даатгал	630,786.43	650,539.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	611,938.23	520,431.79
210204	Ажилгүйдлийн даатгал	116,469.16	97,661.35
210205	Эрүүл мэндийн даатгал	467,405.99	1,120,091.41
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>7,264,338.51</b>	<b>7,222,978.91</b>
210301	Гэрэл, цахилгаан	869,570.55	593,554.07
210302	Түлш, халаалт	6,156,968.36	5,981,267.34
210303	Цэвэр, бохир ус	237,799.60	648,157.50
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>650,500.00</b>	<b>566,418.00</b>
210401	Бичиг хэрэг	87,950.00	105,100.00
210402	Тээвэр, шатахуун	91,900.00	46,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	187,950.00	123,918.00



210404	Ном, хэвлэл	-	8,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282,700.00	282,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	77,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	77,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>488,200.00</b>	<b>288,200.00</b>
210604	Урсгал засвар	488,200.00	288,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>765,000.00</b>	<b>740,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	225,000.00	200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,421,683.20	5,844,354.30
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,421,683.20	5,844,354.30
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	11,721,953.49	1,154,034.15
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	300,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	11,421,953.49	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,421,953.49	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	854,034.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	854,034.15
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(5,222,090.20)</b>	<b>(4,760,754.30)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(5,222,090.20)</b>	<b>(4,760,754.30)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>95,461,900.00</b>	<b>88,795,954.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>99,000.00</b>	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>95,362,900.00</b>	<b>88,795,954.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	95,362,900.00	85,385,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	95,362,900.00	85,385,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	3,410,654.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	3,410,654.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>95,461,900.00</b>	<b>88,730,254.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>95,461,900.00</b>	<b>88,730,254.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>94,961,000.00</b>	<b>84,165,565.85</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	65,929,790.00	66,011,711.00
210101	Үндсэн цалин	55,921,354.00	46,255,437.11
210102	Нэмэгдэл	8,267,138.00	16,147,474.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,741,298.00	3,608,799.69
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,196,218.00	8,318,357.94
210201	Тэтгэврийн даатгал	4,977,228.02	5,929,633.63
210202	Тэтгэмжийн даатгал	512,832.32	650,539.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	561,067.79	520,431.79
210204	Ажилгүйдлийн даатгал	98,669.70	97,661.35
210205	Эрүүл мэндийн даатгал	1,046,420.17	1,120,091.41
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7,264,338.51	7,222,978.91
210301	Гэрэл, цахилгаан	869,570.55	593,554.07
210302	Түлш, халаалт	6,156,968.36	5,884,067.34
210303	Цэвэр, бохир ус	237,799.60	745,357.50
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,948,453.49	566,418.00
210401	Бичиг хэрэг	87,950.00	105,100.00
210402	Тээвэр, шатахуун	91,900.00	46,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,409,003.49	123,918.00
210404	Ном, хэвлэл	76,900.00	8,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282,700.00	282,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	77,000.00	77,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	77,000.00	77,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	488,200.00	288,200.00
210604	Урсгал засвар	488,200.00	288,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,057,000.00	1,680,500.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,517,000.00	1,140,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>500,900.00</b>	<b>4,564,688.15</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	300,000.00	3,710,654.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	3,410,654.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	200,900.00	854,034.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	200,900.00	854,034.15
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	=	<b>65,700.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>65,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>65,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	65,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	65,700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	=	<b>(65,700.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,091,747.00	23,191,251.82	36,282,998.82
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,091,747.00	23,191,251.82	36,282,998.82
D08	Тайлант үеийн үр дүн	-	(4,760,754.30)	(4,760,754.30)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,091,747.00	18,430,497.52	31,522,244.52

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Биелэлт хувиар
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>85,385,300.00</b>	<b>84,531,265.85</b>	<b>854,034.15</b>	<b>0.99</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>85,385,300.00</b>	<b>84,531,265.85</b>	<b>854,034.15</b>	<b>0.99</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>85,085,300.00</b>	<b>84,231,265.85</b>	<b>854,034.15</b>	<b>0.99</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>66,028,900.00</b>	<b>66,011,711.00</b>	<b>17,189.00</b>	<b>1.00</b>
210101	Үндсэн цалин	58,952,200.00	46,255,437.11	12,696,762.89	0.78
210102	Нэмэгдэл	5,413,500.00	16,147,474.20	(10,733,974.20)	2.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,663,200.00	3,608,799.69	(1,945,599.69)	2.17
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>8,913,900.00</b>	<b>8,318,357.94</b>	<b>595,542.06</b>	<b>0.93</b>
210201	Тэтгэврийн даатгал	6,272,700.00	5,929,633.63	343,066.37	0.95
210202	Тэтгэмжийн даатгал	660,300.00	650,539.76	9,760.24	0.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	528,200.00	520,431.79	7,768.21	0.99
210204	Ажилгүйдлийн даатгал	132,100.00	97,661.35	34,438.65	0.74
210205	Эрүүл мэндийн даатгал	1,320,600.00	1,120,091.41	200,508.59	0.85
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>7,449,100.00</b>	<b>7,222,978.91</b>	<b>226,121.09</b>	<b>0.97</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,853,400.00	593,554.07	1,259,845.93	0.32
210302	Түлш, халаалт	4,866,700.00	5,884,067.34	(1,017,367.34)	1.21
210303	Цэвэр, бохир ус	729,000.00	745,357.50	(16,357.50)	1.02
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>647,300.00</b>	<b>632,118.00</b>	<b>15,182.00</b>	<b>0.98</b>
210401	Бичиг хэрэг	105,100.00	105,100.00	-	1.00
210402	Тээвэр, шатахуун	91,900.00	46,000.00	45,900.00	0.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	90,500.00	123,918.00	(33,418.00)	1.37

210404	Ном, хэвлэл	77,100.00	74,400.00	2,700.00	0.96
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282,700.00	282,700.00	-	1.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>77,400.00</b>	<b>77,400.00</b>	-	<b>1.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	77,400.00	77,400.00	-	1.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>288,200.00</b>	<b>288,200.00</b>	-	<b>1.00</b>
210604	Урсгал засвар	288,200.00	288,200.00	-	1.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,680,500.00</b>	<b>1,680,500.00</b>	-	<b>1.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,140,500.00	1,140,500.00	-	1.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00	-	1.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>300,000.00</b>	<b>300,000.00</b>	-	<b>1.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>300,000.00</b>	<b>300,000.00</b>	-	<b>1.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00	-	1.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>85,385,300.00</b>	<b>84,531,265.85</b>	<b>854,034.15</b>	<b>0.99</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>85,385,300.00</b>	<b>84,531,265.85</b>	<b>854,034.15</b>	<b>0.99</b>
132001	Орон нутгийн төсвөөс	85,385,300.00	84,531,265.85	854,034.15	0.99

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-ийн аудитор З.Баттуяа гүйцэтгэж, хяналтыг гүйцэтгэгч талаас тус компанийн чанарын хяналтын менежер М.Бямбадорж, захирал Б.Байгал нар, захиалагч талаас Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер, Б.Эрдэнэ, газрын дарга тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан соёлын төв нь Баянцагаан багийн нутаг дэвсгэрт 2010 оны 10 дугаар сарын 1-нд Орхон аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор иргэдэд урлаг соёлоор үйлчлэх зорилгоор байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.



Баянцагаан соёлын төв нь Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай багц хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай багц хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Соёлын тухай хууль /2022 оны 01 дүгээр сарын 01-ээс дагаж мөрдөнө/ болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж дараах үйлчилгээг иргэдэд үзүүлж байна. Үүнд:

- ✓ Бүх насныханд зориулсан соёл урлагийн арга хэмжээ болон гоцлол болон найрал дуу, бүжиг, шатар даам, гар зураг, гитар, даралтат хөгжмийн дугуйлан хичээллүүлэх,
- ✓ Тогтмол хурал зөвлөгөөн сургалт мөн тэмдэглэлт өдрүүдээр иргэд байгууллагын баярын арга хэмжээ, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус ажлуудыг зохион байгуулах,
- ✓ Номын сан интернэтээр өдөр тутам иргэдэд үйлчлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай багц хууль, Нийгмийн даатгалын тухай багц хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэгт 2021 онд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Тус байгууллагын хувьд 2017 онд БСУГ-аас хандиваар ирсэн 66 төрлийн нийт 1000.0 мянган төгрөгийн номыг Номын фонд дансны дэлгэрэнгүй бүртгэлд нийт өртгөөр бүртгэж тоо ширхэг дээр нь 1 гэж бүртгэгдсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

Дотоод аудитын нэгж байхгүй. Харин Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс ажлын 14 хоногт багтаан дотоод аудитыг хийсэн байна. Уг ажлын хүрээнд 2021 оны 09 дүгээр сарын 21-ний 50/21 дугаар бүхий албан шаардлага 1, ажил сайжруулах 3 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Баян-Өндөр сумын Баянцагаан соёлын төв нь ирүүлсэн зөвлөмжийн талаар арга хэмжээ авч зөрчлөө арилгаж ажилласан байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсөв сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 85,385.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,707.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,195.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлыг тогтоохдоо тайлант оны батлагдсан санхүүжилтийн дүнг суурь болгож авсан. Гүйцэтгэлийн үе шатанд суурь өөрчлөөгүй, гүйцэтгэлийн санхүүжилтийн дүнг суурь болгож авахад 17.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг бууруулах зөрүү үүссэн. Тиймээс ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдал 1,690.6 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдал 1,183.4 мянган төгрөгөөр тогтоов.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан Соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,760.7 мянган төгрөгөөр буюу 13.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	11,486.46	12,504.36	1,017.90	8.86%
Үндсэн хөрөнгө	24,796.54	19,017.88	-5,778.65	-23.30%
<b>Нийт хөрөнгө</b>	<b>36,283.00</b>	<b>31,522.24</b>	<b>-4,760.75</b>	<b>-13.12%</b>
Засгийн газрын оролцоо	36,283.00	31,522.24	-4,760.75	-13.12%
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмч</b>	<b>36,283.00</b>	<b>31,522.24</b>	<b>-4,760.75</b>	<b>-13.12%</b>

Тус байгууллага нь Төрийн санд үндсэн болон нэмэлт санхүүжилтийн гэсэн 2 данстай.

Үндсэн санхүүжилтийн харилцах 100210135013 тоот дансаар 88,795.9 мянган төгрөгийн орлого орж, зарцуулагдсан байна. Үүний 85,385.3 мянган төгрөг нь санхүүжилтийн орлого, 3,410.6 мянган төгрөг нь нэр данс зөрүү буюу буцсан гүйлгээ байна. Нэмэлт санхүүжилтийн 100210135401 тоот дансаар орлого ороогүй байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 8.86%-аар буюу 1,017.9 мянган төгрөгөөр өссөн байна. Уг өсөлтөд дараах бараа материалуудын хөдөлгөөн нөлөөлсөн байна. Үүнд:

- Оны эцэст уран бүтээлийн зардлаас 2 ширхэг дээл 500.0 мянган төгрөгөөр худалдан авч тусгай зориулалтын материалд бүртгэгдсэн, аж ахуйн материал 517.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд худалдан авсан ажлын халаад, хулдаасан хэвлэлийг аж ахуйн материалын үлдэгдлээр бүртгэгдсэн байна.
- Бичиг хэргийн материал, аж ахуйн материал, шатахуун, барилгын засварын материалын орлого, зарцуулалт нь өмнөх оноос өсөөгүй, бараа материалын нөөц үүсгээгүй байна.
- Аж ахуйн материал өмнөх онд үйлдэгдэлтэй байсан нь байгууллагын тамга, санхүүгийн тамга тэмдгийг аж ахуйн материалаар ангилал зөрчиж бүртгэсэн нь үлдэгдлээр харагдаж байна.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 23.3%-аар буюу 5,778.6 мянган төгрөгөөр буурсан байна. Үүнд: Ном хэвлэлийн зардлаас 65.7 мянган төгрөгийн өртөгтэй 3 ширхэг ном худалдан авсан ба 5,844.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлын дүнгээр буурсан байна.
- Өр төлбөрийн дансанд өөрчлөлт ороогүй энэ онд тус байгууллага өр төлбөр, өглөг байхгүй.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 4,760.7 мянган төгрөгөөр буюу 13.12 %-аар буурсан байна. Үүнд тайлант үеийн үр дүнгийн хэтрэлт нөлөөлсөн байна. Төрийн өмчид өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 2. Орлогын үзүүлэлт /мянган төгрөг/

Орлогын нэр төрөл	2020 он	2021 он	Өөрчлөлт	Хувь
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	95,362.90	85,385.30	-9,977.60	-10.46%
<b>Нийт орлого</b>	<b>95,362.90</b>	<b>85,385.30</b>	<b>-9,977.60</b>	<b>-10.46%</b>

2021 онд тус байгууллагын нийт орлого өмнөх оноос 9,977.6 мянган төгрөгөөр буюу 10.46%-аар буурсан. Нэмэлт орлого байхгүй. Орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтийн орлогын дүнгээр буурсан байна.

Хүснэгт 4. Зардлын үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	2020	2021	Өөрчлөлт	Хувь
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>100,584.99</b>	<b>90,146.05</b>	-10,438.94	-10.4%
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>100,584.99</b>	<b>90,146.05</b>	-10,438.94	-10.4%
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>88,863.04</b>	<b>88,992.02</b>	128.98	0.1%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	65,929.79	66,011.71	81.92	0.1%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,266.53	8,318.36	1,051.83	14.5%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,264.34	7,222.98	-41.36	-0.6%
Хангамж, бараа материалын зардал	650.50	566.42	-84.08	-12.9%
Нормативт зардал	77.00	-	-77.00	-100.0%
Эд хогшил, урсгал засварын зардал	488.20	288.20	-200.00	-41.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	765.00	740.00	-25.00	-3.3%
Бараа үйлчилгээний бусад зардал	6,421.68	5,844.35	-577.33	-9.0%
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,721.95</b>	<b>1,154.03</b>	-10,567.92	-90.2%
Бусад урсгал шилжүүлэг	300.00	300.00	0.00	0.0%
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,421.95	-	-11,421.95	-100.0%
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	854.03	854.03	

Нийт зардал өмнөх оноос 10.4%-аар буюу 10,438.9 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант он үйл ажиллагааны бус зардал гараагүй байна. Үйл ажиллагааны зардлын бууралтын нөлөөлөл нь:

- ✓ Бараа, ажил үйлчилгээний зардлын бууралтад байр ашиглалттай холбоотой зардал 0.6%-аар буюу 41.4 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 12.9%-аар буюу 84.1 мянган төгрөг, нормативд зардал 100%-аар буюу 77.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 41.0%-аар буюу 200.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 3.3%-аар буюу 25.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 9.0%-аар буюу 577.3 мянган төгрөгөөр буурсан нь тус тус байна.
- ✓ Урсгал шилжүүлгийн зардлын бууралт татан төвлөрүүлэлтийн дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд бараа үйлчилгээний зардлыг 85,085.3 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 300.0 мянган төгрөгөөр, нийт 85,385.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Батлагдсан төсвийн зарлага болох 85,385.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр баталжээ.

Тус байгууллагын 2021 оны төсөвт зардал, уг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт тодотгол хийгдээгүй. Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 5-д үзүүлэв.

5 Төсвийн төлөвлөлтийн үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төсвийн төлөвлөлт			2020/2021 оны зөрүү	Хувь
		2020 оны төсвийн төлөвлөгөө	2021 оны анхны батлагдсан төлөвлөгөө	2021 оны батлагдсан төлөвлөгөө		
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	95,285.50	85,385.30	85,385.30	9,900.20	89.61%

21	УРСГАЛ ЗАРДАЛ	95,285.50	85,385.30	85,385.30	9,900.20	89.61%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	94,985.50	85,085.30	85,085.30	9,900.20	89.58%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	71,028.90	66,028.90	66,028.90	5,000.00	92.96%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,878.30	8,913.90	8,913.90	-35.60	100.40%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,449.60	7,449.10	7,449.10	4,000.50	65.06%
2104	Хангамж, бараа материалын зардал	647.20	647.30	647.30	-00.10	100.02%
2105	Нормативт зардал	-	77.40	77.40	-77.40	0.00%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	488.20	288.20	288.20	200.00	59.03%
2107	Томилолт, зочны зардал	137.80	00.00	00.00	137.80	0.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,232.90	1,680.50	1,680.50	552.40	75.26%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	122.60	0.00	0.00	122.60	0.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300.00	300.00	300.00	00.00	100.00%
2131	Бусад урсгал шилжүүлэг	300.00	300.00	300.00	00.00	100.00%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>95,362.90</b>	<b>85,385.30</b>	<b>85,385.30</b>	<b>9,977.60</b>	<b>89.54%</b>
1320	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	95,362.90	85,385.30	85,385.30	9,977.60	89.54%

Дээрх төсвийн төлөвлөлтийн өөрчлөлтөд үзүүлсэн нөлөөллийн хүчин зүйлүүдийг тайлбарлан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, Ажил олгогчоос төлөх НДШ: 2021 онд уг зардлыг санхүүжүүлэх төсөв өмнөх оны батлагдсан төлөвлөгөөнөөс 7.0%-аар буюу 5000.0 мянган төгрөгөөр буурсан байна.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: Өмнөх оноос 34.9%-аар буюу 4000.0 мянган төгрөгөөр буурсан
- Хангамж, бараа материалын зардал: Өмнөх оноос 0.02%-аар буюу 0.1 мянган төгрөгөөр өссөн.
- Эд хогшил, урсгал засварын зардал: Өмнөх оноос 40.9%-аар буюу 200.0 мянган төгрөгөөр буурсан байна энэ онд засвар үйлчилгээ хийгээгүйтэй холбоотой байна.
- Томилолт, зочны зардал: Өмнөх оноос 100%-аар буюу 137.8 мянган төгрөгөөр буурсан буюу тайлант онд уг зардлыг төлөвлөөгүй.
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж: Өмнөх оноос 24.7%-аар буюу 552.4 мянган төгрөгөөр буурсан.
- Бараа үйлчилгээний бусад зардал: Өмнөх оноос 100%-аар буюу 122.6 мянган төгрөгөөр, буурсан байгаа нь тухайн онд уг зардлыг төлөвлөөгүй байна.

2021 оны батлагдсан төлөвлөгөө 2020 оны батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад төсөв буурсан буюу энэ төсвийн хэмнэлттэй холбоотой. 2021 оны төсвийн төлөвлөлтөд нэмэлт зохицуулалт хийгдээгүй тайлант онд хэмнэлтэй зарцуулсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 85,385.3 мянган төгрөгийн төсөв баталж орон нутгийн төсвийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 84,531.3 мянган төгрөг буюу 99% байна. Төсвийн гүйцэтгэлийн хэлбэлзлийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 6 Төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлт /мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Биелэлт хувиар
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	85,385.30	84,531.26	854.04	0.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	85,385.30	84,531.26	854.04	0.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	85,085.30	84,231.26	854.04	0.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	66,028.90	66,011.71	17.19	1.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,913.90	8,318.36	595.54	0.93

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,449.10	7,222.98	226.12	0.97
2104	Хангамж, бараа материалын зардал	647.30	632.12	15.18	0.98
2105	Нормативд зардал	77.40	77.40	-	1.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	288.20	288.20	-	1.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,680.50	1,680.50	-	1.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300.00	300.00	-	1.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300.00	300.00	-	1.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>85,385.30</b>	<b>84,531.26</b>	<b>854.04</b>	<b>0.99</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>85,385.30</b>	<b>84,531.26</b>	<b>854.04</b>	<b>0.99</b>
132001	Орон нутгийн төсвөөс	85,385.30	84,531.26	854.04	0.99

Тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 17.2 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 595.5 мянган төгрөгийн, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 226.1 мянган төгрөгийн, хангамж, бараа материалын зардлаас 15.2 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна. Үүний үр нөлөөгөөр төсөвт зардал 0.1%-аар хэмнэгджээ. Харин орон нутгийн төсвөөс тайлант онд гүйцэтгэлээр 85,385.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үүнээс 84,531.3 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 854.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дах заалтад “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт орлого ороогүй байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитын хийх явцад аудитын баг холбогдох нотлох баримтыг саадгүй авч ашигласан бөгөөд тайлант оны санхүүгийн ажил гүйлгээ санхүүгийн тайланд толилуулсан мэдээллийн хүрээнд аудит хийгдсэн.

### 3.8 Аудитын гол асуудал

#### Бараа материалын ангилал бүртгэлтэй холбоотой асуудал

Бараа материал, үндсэн хөрөнгийг орлогод авахдаа ангилал зөрчих. Олон төрлийн хөрөнгө худалдан авч орлогод авахдаа нягтлан бодох бүртгэлийн программд нэр төрөл тус бүрээр нь бүртгэхгүй бөөн дүнгээр бүртгэх алдаа ажиглагдсан.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг авч үзвэл тус байгууллага нь шилэн дансанд нийт 151 талбарт мэдээ оруулахаас 151 талбарт мэдээ оруулсан ба хэрэгжилт 100% байна. Улирал бүр аймгийн СХДАА-аас хяналт шалгалт хийгдэж, зөрчилгүй дүгнэгдсэн байна.



Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Дээрх нөхцөл байдал болон энэ тайлангийн аудитын илрүүлэлт хэсэгт тусгагдсан асуудлуудаас бусад хууль тогтоомжид нийцээгүй зүйл бидэнд ажиглагдаагүй болно.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах 1 зөвлөмжийг өгсөн ба хэрэгжилт 100% хувьтай байна.

*Хүснэгт 7 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	1		1				
<b>Нийт дүн</b>	<b>1</b>		<b>1</b>				

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 09 тоот албан бичгээр Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, картжуулалт, үндсэн хөрөнгийн паспорт хөтлөлт, хөрөнгөд тавигдах дотоод хяналтын талаар дараагийн аудитаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,000.0 мянган төгрөгийн материаллаг бус алдаа зөрчил илэрснээс 1,000.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа байхгүй залруулга хийгдээгүй.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тавигдаагүй болно.

### 4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага тавигдаагүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

БСУГ-аас хандиваар ирсэн 66 төрлийн нийт 1,000.0 мянган төгрөгийн номыг номын фонд дансны дэлгэрэнгүй бүртгэлд 1 ширхгээр бүртгээд нэгжийн өртгийг 1,000.0 мянган төгрөгөөр бүртгэгдсэн байна. Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаал "Маягт аргачлал

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

батлах тухай"-ын үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл ҮХ-1-ийг зөрчиж толилуулга, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

CTS программд хөрөнгүүдийг нэр төрөл тус бүрээр нь нэг бүрчлэн оруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан соёлын төв	1	1,000.0	-	-	-	-	-	-	1	1,000.0

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

БЭЛТГЭСЭН:

"МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ" ХХК-ИЙН

АУДИТОР:

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

ЗАХИРАЛ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР:

З.БАТТУЯА Огноо: 2022.02.24

М.БЯМБАДОРЖ

Огноо:

Б.БАЙГАЛ

Огноо:

Б.ЭРДЭНЭ

Огноо:

Ц.НАРМАНДАХ

Огноо:

